



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 09 сарын 09 өдөр

Дугаар 4/89

Улаанбаатар хот


┌ Сургалтад хамруулах тухай ─┐

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 27.1.9, Засгийн газрын 2011 оны 62 дугаар тогтоолын 3.2.4, Төсвийн тухай хуулийн 16.5.5, Хөдөлмөрийн дотоод журмын 6.1.13, тус газрын Дүрмийн 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Япон улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллагаас Япон улсад 2015 оны 09 дүгээр сарын 27-ноос 11 дүгээр сарын 09-ний хооронд зохион байгуулах “Аялал жуулчлалын хөгжлийн бодлого” тэтгэлэгт сургалтад Төсөл, хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн Батсайханы Халиуныг хамруулсугай.

2. Б.Халиуны сургалтад хамрагдах хугацааны цалин хөлсийг зохих журмын дагуу тооцож олгохыг Ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д, албан үүргийг нь түр орлон гүйцэтгэхийг Эвент хариуцсан мэргэжилтэн /М.Болортуяа/-д тус тус даалгасугай.

ДАРГА



Э.БАТТУЛГА